



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 07/11

Арвайхээр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр "Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд төв суурин газрын нийтийн эзэмшлийн талбайд тарих модны тарьц, суулгац худалдан авч сумдад нийлүүлэх" гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: М.Мөнхсүрэн (Аялал жуулчлалын асуудал

хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

Т.Гантулга (Орон нутгийн өмчийн газрын Худалдан

авах ажиллагааны албаны мэргэжилтэн)

Г.Даваатогтох (Иргэдийн төлөөлөл)

А.Оюунчимэг ("Орон нутгийн сургалт судалгаа

хөгжлийн агентлаг" ТББ-ын удирдах зөвлөлийн дарга)

Нарийн бичгийн дарга:

Ц.Болдбаатар (Газар, газрын хэвлий түүний

баялгийн ашиглалт, нөхөн сэргээлт, байгаль орчны

үнэлгээ-аудит хариуцсан мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан мэдэгдэл гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо дарга (М.Мөнхсүрэн)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр холбогдох хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив-бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ц.Болдбаатар)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Т. БАЯСГАЛАН

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ГЭДГЭЭ ИЛЭРХИЙЛЭХ,
ЗӨРЧИЛ ҮҮССЭН ТУХАЙ МЭДЭГДЭЛ

Нэг. Нийтийн албан тушаалтан

Ургийн овог: Монгол	Эцэг (эх)-ийн нэр: Гэндэн	Нэр: Баясгалан
Албан тушаал: Газрын дарга	Ажиллаж байгаа байгууллага: Аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газар	
Албан тушаалд томилогдсон он, сар, өдөр: 2021.02.16 6/05	Байгууллагын хаяг: Нутгийн удирдлагын ордон 502 тоот	
Албан үүргийн төрөл: Тушаал	Тайлбар: Үнэлгээний хороо байгуулах тухай	

Сонирхлын зөрчилтэй эсэх Тийм ☐ Үгүй ☒

Хоёр. Сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн байдал

Нийтийн албан тушаалтан Гэндэнгийн Баясгалан би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэхэд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан сонирхлын зөрчилгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

Гурав. Сонирхлын зөрчил үүссэн тухай

Нийтийн албан тушаалтан би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэх хүрээнд:


- ☐ гаргах, гаргахад оролцох шийдвэр нь хамаарал бүхий этгээдтэй холбоотой гэх /хувь хүн, хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны чиглэл/:
- ☐ гэрээ хэлцэл, хэлэлцээрийн оролцогч, эсхүл зээл, хандив, тусламж, үйлчилгээг хувь хүн, хуулийн этгээдээс авч байсан /байгаа/-тай холбогдуулж үүрэг хүлээсэн гэх:
- ☐ байгууллага, хуулийн этгээдэд ажиллаж байсан, гишүүнчлэлтэй, эсхүл төлөөлөл хэрэгжүүлж байсан /байгаа/ гэх:
- ☐ Бусад /сонирхлын зөрчилтэй бусад нөхцөл байдал/:

нөхцөл байдал бий болсон гэж үзэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу сонирхлын зөрчил үүссэнийг мэдэгдэж, албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж байна.

Дөрөв. Баталгаажуулалт.

Би нийтийн албан хаагчийн үүргээ чанд, ухамсарлан энэхүү мэдэгдлийг үнэн зөв гаргасан болохоо үүгээр баталгаажуулж байна.

Дарга
/албан тушаал/


/гарын үсэг/ Н.Баясгалан/
/нэр/
2021 он 04 сар 08 өдөр
6216271138-9129944

Шийдвэрлэсэн байдал

Ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрөх эсэх

Тийм ☐ Үгүй ☐

Хэрэв "Тийм" бол шалтгааныг тэмдэглэнэ үү.

- ☐ Тухайн албан үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй
- ☐ Дээд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томилон ажиллуулах боломжгүй
- ☐ Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардагдсан албан тушаалтан байхгүй

Баталгаажуулалт:

..... /албан тушаал/ /гарын үсэг/ /нэр /
..... он сар өдөр